



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/252

Улаанбаатар хот

Автомашин шилжүүлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Япон Улсад 2015 онд үйлдвэрлэсэн, 65,659,035.04 /жаран таван сая зургаан зуун тавин есөн мянга гучин таван төгрөг дөрвөн мөнгө/ төгрөгийн балансын өртөгтэй, 10,109,839.20 /арван сая нэг зуун есөн мянга найман зуун гучин есөн төгрөг хорин мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэлийн өртөгтэй, арлын JTDKN36U901994437, улсын 80-59 УНЗ дугаартай, "Тоёота приус-30" маркийн суудлын автомашиныг Өмнөговь аймаг дахь цагдаагийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Шилжүүлсэн автомашиныг данс бүртгэлээс хасалт хийх, орлогод авч, нягтлан бодох бүртгэлийн тайланд зохих журмын дагуу тусгахыг холбогдох байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, аж ахуйн албаны дарга /цагдаагийн хурандаа Ж.Эрдэнэболд/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА

ХУУЛБАР ҮНЭН
Захиргааны удирдлагын газрын дарга,
цагдаагийн хурандаа



С.БААТАРЖАВ

Б.Бат-Өлзий

Handwritten signature

0904195